



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 67.

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах,
журам батлах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5 дахь хэсэг, тус газрын дүрмийн 2.3, 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн, аж ахуйн нэгжид Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох явцад хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн
ахлагч:

Д.Ганболд

Ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Э.Мөнхзул

Мэргэжилтэн

Г.Гансувд

Мэргэжилтэн


2. Ажлын хэсгийн үйл ажиллагааны журмыг хавсралтаар баталсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2013 оны 10 сарын 27-ны
өдрийн 67 тоот тушаалын хавсралт



**УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
БАЙР СУУЦНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЯВЦАД
ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох явцын ил тод байдал, стандартын шаардлага хангаж байгаа байдал болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлж дүгнэсэн байдлыг нягтлахад оршино.

ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

2.1. Ажлын хэсэг нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагуудаас баталсан дүрэм журмыг мөрдөнө.

2.2. Ажлын хэсгийн гишүүд нь тухайн ажлын хэсэгт орж ажилласнаар ямар нэгэн нэмэлт цалин хөлс, урамшуулал авахгүй.

2.3. Ажлын хэсэг нь холбогдох мэргэжилтний зөвшөөрөл олгохоор санал оруулж байгаа байгууллага бүрийн материал баримт бичгийн бүрдэл, гэрэл зураг, видео бичлэг зэргийг үндэслэн дараах тэмдэглэлийг хөтөлж гишүүн бүр гарын үсэг зурна.

АЖЛЫН ХЭСГИЙН ТЭМДЭГЛЭЛ

д/д	Аж ахуйн нэгж, иргэний нэр	Байгууллагын оноосон нэр	Дүүрэг хороо	Гудамж байршил	Гишүүдийн санал	Гишүүдийн гарын үсэг

ГУРАВ. ШИЙДВЭР ГАРГАХ

3.1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдааны тэмдэглэл болон газрын даргад хүргүүлэх зөвлөмж нь ажлын хэсгийн шийдвэр байна.

3.2. Ажлын хэсэг нь зөвшөөрөл олгох тушаал гаргах бүрт хуралдаж газрын даргад зөвлөмж хүргүүлнэ.

3.3. Ажлын хэсэг нь хэлэлцэж буй асуудлаар санал зөрөлдсөн тохиолдолд олонхын саналаар шийдвэрлэнэ.

3.4. Ажлын хэсэг нь бүрэн бүрэлдэхүүнээрээ буюу гурван гишүүний ирцтэйгээр хуралдсан тохиолдолд эсвэл хоёр гишүүн санал нэгтэйгээр зөвлөмж гаргаж болно.

3.5. Баримт бичгийн бүрдэл дутуу, бодит бусаар дүгнэсэн, шаардлага хангаагүй газруудад зөвшөөрөл олгохоор санал оруулж ирсэн тохиолдолд илэрсэн зөрчлийг арилгах хүртэл зөвшөөрөл олгохоос татгалзах зөвлөмжийг газрын даргад хүргүүлнэ.

-ooOoo-